PBSA AUDIT LLC

АУДИТ
БАТАЛГААЖУУЛАЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ

АУДИТОРЫН ТАЙЛАН

"МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС" ББСБ

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн эцсийн САНХҮҮГИЙН ТАЙЛАН аудиторын дүгнэлтийн хамт

Хаяг: Улаанбаатар хот, Чингилтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, Гэрэл төв оффис, 302 тоот

“МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС” ББСБ
Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр	“МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС” ББСБ -н хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр банк бус санхүүгийн байгууллага хязгаарлагдмал хариуцлагатай Банк бус санхүүгийн байгууллагаар үүсгэн байгуулагдсан. Монкон группын 5000000 мянган төгрөгийн хөрөнгө оруулалттай. Факторингийн үйлчилгээ, Зээлийн үйл ажиллагаа чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулах зорилгоор байгуулагдсан байна. Гүйцэтгэх захирлаар Л.Батхуяг-г томилсон байна.
Гэрчилгээ ба Лиценз	2014.05.15 -нд Монгол Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн байна. Улсын бүртгэлийн дугаар: 9015005094 Регистрийн дугаар: 5842999
Тусгай зөвшөөрөл	Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй.Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй.Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй.
Хөрөнгө оруулагчид	Монкон группын 5000000 мянган төгрөгийн хөрөнгө оруулалттай байна.
Гүйцэтгэх Удирдлага	/Гүйцэтгэх Захирал/ Л.Батхуяг
Хаяг	“МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС” ББСБ Хаяг: СБД 1-р хороо олимпийн гудамж, 4-р барилга, 13 давхар 01 тоот Утас: (+976) –, 99085645 E-mail: selenge.l@moncon.mn,
Аудитор	ТӨГС СУУРЬ СТАНДАРТ АУДИТ ХХК Хаяг: Улаанбаатар хот, Чингилтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, Гэрэл төвийн оффис, 302 тоот Утас: (+976)-72330760, 99010760 E-mail: tcc.audit.mn@gmail.com

PBSA AUDIT LLC
АУДИТ
БАТАЛГААЖУУЛАЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ

Улаанбаатар хот, Чингилтэй дүүрэг, 1-р хороо,
Жигжиджавын гудамж, Гэрэл төвийн оффис, 302 тоот
Утас: (+976)-72330760, 99010760
И-майл: tcc.audit.mn@gmail.com

"МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС" БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

"МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС" ББСБ (цаашид Банк бус санхүүгийн байгууллага гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

"МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС" ББСБ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан журмуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Зөрчилгүй дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (цаашид АУОС гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн аудиттай холбоотой Аудиторын үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчийн Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ийн дүрэм" гэх)-ийн дагуу тус байгууллагаас хараат бус, бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудал юмаа. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Татварын тооцооллын үнэн зөв байдал

Татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монгол улсын Засгийн газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Эрх бүхийн өөр өөр байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Татварын хууль тогтоомжийн ойлголт дээр үндэслэн бүх татварыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн банк бус санхүүгийн байгууллагад татварын эрсдэл байсаар байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ.Бусад мэдээлэл нь жилийн тайланд багтсан хэдий ч санхүүгийн тайлан ба аудиторын тайланд багтаагүй мэдээллээс бүрдэнэ.

Энэхүү санхүүгийн тайланд өгөх бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг бэлэн болсон үед унших үүрэгтэй бөгөөд, бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой.

Бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд, бид бусад горимыг гүйцэтгэж, бусад мэдээлэл материаллаг хэмжээний алдаа байгаа гэж үзсэн ба түүнийг залруулаагүй бол, залруулаагүй материаллаг хэмжээний алдааг манай

тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд хүргэхийн тулд бид зохистой арга хэмжээ авахыг засаглах эрх бүхий этгээдээс хүсэх болно.
Хэрэв бид банк бус санхүүгийн байгууллагад аудит хийсэн санхүүгийн тайлан, байгууллагын орчны талаарх бидний ойлголтод материаллаг хэмжээний алдаа байна гэж үзвэл, бид АОУС-ын дагуу холбогдох арга хэмжээ авна.

Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг
Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх,санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй
Санхүүгийн тайланг бэлтгэхдээ банк бус санхүүгийн байгууллага татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага байгууллагын үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайланг бэлтгэх үүрэгтэй. Засаглах эрх бүхий этгээд нь банк бус санхүүгийн байгууллага санхүүгийн тайлангийн үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Аудиторын үүрэг
Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа, эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үүдлээс үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайлан
д үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

Тайлангийн хэрэглээ
Бид энэхүү тайланг хуулийн этгээд болох "МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС" ББСБ-ийн удирдах зөвлөлд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Т.Батсайхан захирал,
"Төгс Суурь Стандарт Аудит" ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2026/02/05

СТА-1

"МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС " ББСБ *РД: 5842999*

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл (төгрөг)	Эцсийн үлдэгдэл (төгрөг)
1	**ХӨРӨНГӨ**		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	437,460,585.78	707,673,566.45
1.2	Зээл	4,777,275,253.50	8,256,959,240.47
1.3	Факторингийн тооцооны авлага	4,636,593,765.00	2,276,357,032.70
1.4	Үүсмэл санхүүгийн хөрөнгө	-	-
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	417,337,444.72	477,375,232.72
1.7	**Санхүүгийн хөрөнгийн дүн**	**10,268,667,049.00**	**11,718,365,072.34**
1.8	Татвар, НДШ-ийн авлага	55,691,395.99	-
1.9	Үндсэн хөрөнгө	2,789,672.30	11,712,449.22
1.10	Биет бус хөрөнгө	428,600.05	1,818,993.82
1.11	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнг	-	-
1.12	Бусад санхүүгийн бус хөрөнгө	-	3,997,115.00
1.13	**Санхүүгийн бус хөрөнгийн дүн**	**58,909,668.34**	**17,528,558.04**
1.14	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**10,327,576,717.34**	**11,735,893,630.38**
2.1	Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	-	-
2.3	Бусад эх үүсвэр	2,355,163,290.42	2,787,000,000.00
2.5	Бусад санхүүгийн өр төлбөр	10,651,185.57	668,731.00
2.6	Хоёрдогч өглөг	-	-
2.7	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
2.8	**Санхүүгийн өр төлбөрийн дүн**	**2,365,814,475.99**	**2,787,668,731.00**
2.9	Татвар, НДШ-ийн өр төлбөр	90,609,723.18	72,634,791.07
2.13	**Санхүүгийн бус өр төлбөрийн дүн**	**90,609,723.18**	**72,634,791.07**
2.14.	**НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН**	**2,456,424,199.17**	**2,860,303,522.07**
3	**Өмч**	-	-
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000,000,000.00	5,000,000,000.00
3.2	Өмчийн бусад хэсэг	-	-
3.3	Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	2,871,152,518.17	3,875,590,108.31
3.4	**НИЙТ ӨМЧИЙН ДҮН**	**7,871,152,518.17**	**8,875,590,108.31**
3.5	**НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН**	**10,327,576,717.34**	**11,735,893,630.38**

PES-AUDIT

СТА-2

"МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС " ББСБ **РД: 5842999**

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (төгрөг)	Эцсийн үлдэгдэл (төгрөг)
1	**Хүүгийн орлого**	-	-
1.1	Банканд байршуулсан хөрөнгийн	15,024,555.71	-
1.3	Зээлийн	848,672,216.45	1,845,872,107.10
1.5	Бусад	418,714,423.00	596,923,713.34
1.6	(Хүүгийн орлогын буцаалт)	-	-
1.7	**Хүүгийн орлогын дүн**	**1,282,411,195.16**	**2,442,795,820.44**
2.2	Зээлийн	-	516,474,818.86
2.4	Бусад	231,031,232.92	382,699,660.59
2.6	**Хүүгийн зардлын дүн**	**231,031,232.92**	**899,174,479.45**
3	**3.Хүүгийн цэвэр орлого (1.7-2.6)**	**1,051,379,962.24**	**1,543,621,340.99**
5	**Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого (3-4)**	**1,051,379,962.24**	**1,543,621,340.99**
6	**Бусад орлого**	**48,557,886.70**	**40,096,389.15**
6.1	Хүүгийн бус орлого	48,557,886.70	40,096,389.15
7	**Бусад зардал**	**481,144,560.14**	**464,674,402.33**
7.1	Хүүгийн бус зардал	477,116,309.25	428,069,473.44
7.2	Бусад зардал, гарз	4,028,250.89	36,604,928.89
8	**Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)**	**618,793,288.80**	**1,119,043,327.81**
9	Орлогын татварын зардал	6,187,932.89	114,605,737.67
10	**Татварын дараах ашиг, алдагдал (8-9)**	**612,605,355.91**	**1,004,437,590.14**
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	-
12	**Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)**	**612,605,355.91**	**1,004,437,590.14**
13	.Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
14	**Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)**	**612,605,355.91**	**1,004,437,590.14**

PBS-AUDIT

СТА-3

"МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС " ББСБ

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга**	-	-	**0.0**
2	Залруулсан үлдэгдэл	2,500,000,000.00	2,258,547,162.26	**4,758,547,162.3**
3	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	612,605,355.91	**612,605,355.9**
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	**0.0**
5	Өмчид гарсан өөрчлөлт	2,500,000,000.00	-	**2,500,000,000.0**
6	Хуваарилсан ногдол ашиг	-	-	**0.0**
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	**0.0**
8	**2024 ОНЫ 12-Р САРЫН 31-НЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ**	5,000,000,000.00	2,871,152,518.17	**7,871,152,518.2**
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	**0.0**
10	Залруулсан үлдэгдэл	5,000,000,000.00	2,871,152,518.17	**7,871,152,518.2**
11	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	1,004,437,590.14	**1,004,437,590.1**
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	**0.0**
13	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	**0.0**
14	Хуваарилсан ногдол ашиг	-	-	**0.0**
15	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	**0.0**
16	**2025 ОНЫ 12-Р САРЫН 31-НЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ**	5,000,000,000.00	3,875,590,108.31	**8,875,590,108.3**

PBS-AUDIT

СТА-4

"МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС " ББСБ

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (төгрөг)	Эцсийн үлдэгдэл (төгрөг)
1	**ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**	-	-
1.1	Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	3,525,448,782.60	12,683,428,841.13
1.4	Факторингийн үйл ажиллагаанаас хүлээн авсан	7,153,953,538.42	5,152,021,845.64
1.5	Бусад	63,582,442.41	40,096,389.15
1.6	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого**	**10,742,984,763.43**	**17,875,547,075.92**
1.7	Олгосон зээл	3,210,886,304.00	14,317,240,721.00
1.10	Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн	10,816,669,590.00	2,425,024,690.42
1.11	Ажиллагсдад олгосон	142,926,809.72	192,806,811.41
1.12	Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	164,429,797.18	138,569,437.63
1.13	Ашиглалтын зардалд төлсөн	-	192,171.00
1.14	Бусад	320,400,499.20	275,311,719.96
1.15	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага**	**14,655,313,000.10**	**17,349,145,551.42**
1.16	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,912,328,236.67)	526,401,524.50
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
2.1	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	7,655,026.19	5,664,974.91
2.2	Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан	2,500,000,000.00	-
2.4	Үнэт цаас борлуулснаас хүлээн авсан	1,800,000,000.00	2,462,000,000.00
2.6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	4,307,655,026.19	2,467,664,974.91
2.7	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,403,670.00	15,978,145.60
2.10	Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	231,031,232.92	2,182,699,660.59
2.12	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага**	**232,434,902.92**	**2,198,677,806.19**
2.13	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**4,075,220,123.27**	**268,987,168.72**
3.1	Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан	-	5,180,000,000.00
3.4	Бусад	1,013,881,463.17	1,853,569,405.44
3.5	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого**	**1,013,881,463.17**	**7,033,569,405.44**
3.6	Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн	-	5,696,474,818.86
3.9	Бусад	971,965,390.99	1,862,270,299.13
3.10	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага**	**971,965,390.99**	**7,558,745,117.99**
3.11	**1 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**41,916,072.18**	**-525,175,712.55**
5	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**204,807,958.78**	**270,212,980.67**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**232,652,627.00**	**437,460,585.78**
7	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**437,460,585.78**	**707,673,566.45**

PBS-AUDIT

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Товч танилцуулга:

"МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС" банк бус санхүүгийн байгууллага нь 2014.05.15 -нд Монгол улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн байна.
Монкон групп-н 5000000 мянган төгрөгийн хөрөнгө оруулалттай.

Улсын бүртгэлийн дугаар	9015005094
Регистрийн дугаар	5842999
Үүсгэн байгуулагдсан огноо:	2014.05.15

1.2 Хаяг: СБД 1-р хороо олимпийн гудамж, 4-р барилга, 13 давхар 01 тоот
Утас: ,
И-майл: selenge.l@moncon.mn

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй "Аудитын тухай хууль", Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", СТОУС, болон бусад холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажилласан.

Аудитын дүгнэлт гаргахдаа "МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС" ББСБ ХХК-иас бидэнд танилцуулсан санхүүгийн болон зээлийн баримт материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

Байгууллагын зорилт үндсэн үйл ажиллагаа

Тус банк бус санхүүгийн байгууллагын эрхэм зорилго нь: санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн түвшинд бүтээлч ба найдвартай ажиллагаагаар Бичил, жижиг дунд бизнес шинээр эхэлж байгаа болон тогтвортой эрхлэгч иргэд, нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгж байгууллага, бага дунд орлоготой өрхүүдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжин хөрөнгө оруулалт хийхэд оршино.

Тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу дараах үйл ажиллагааг явуулж байна.

- Зээлийн үйл ажиллагаа
- Факторингийн үйлчилгээ

1. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Нийтлэг зориулалттай санхүүгийн тайланд тусгах мэдээлэл нь: хамааралтай байх, үнэн зөв илэрхийлсэн, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэх боломжтой байх, шалгах боломжтой байх зэрэг шинэ чанаруудыг хангасан байх ёстой.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүүгийн тайлан бэлтгэхэд дараах ерөнхий зарчмыг баримтална.

- ✓ Санхүүгийн тайланг аккруэл суурьт нийцүүлэн бэлтгэнэ.
- ✓ Санхүүгийн тайланд санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй бүртгэл, мөнгөн гүйлгээ, нэмэлт тайлбар тодруулгыг үнэн зөв толилуулна.
- ✓ Байгууллагыг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй байх сууриар бэлтгэнэ.

PBS-AUDIT

- ✓ Санхүүгийн тайлан дахь толилуулгыг ба ангиллыг нэг үеэс дараагийн үед тогтвортой хадгална.

- ✓ Санхүүгийн тайланд материаллаг зүйлсийг тусад нь толилуулна. Материаллаг бус дүнтэй зүйлсийг шинж чанараар буюу үүргийнх нь дагуу ижил зүйлсийн дүнтэй нэгтгэн толилуулна.

- ✓ Байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох тайлангийн маягтын дагуу өмнөх үеийн мэдээлэлтэй зэрэгцүүлсэн байдлаар толилуулна.

- ✓ Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандартаар шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд аж ахуйн нэгж нь хөрөнгө ба өр төлбөр, эсхүл орлого ба зардлыг хааж, цэвэр дүн гаргахгүй.

2.1 Санхүүгийн тайланг бэлтгэх үндэслэл:

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандарт (СТОУС) түүнд нийцүүлэн Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу тайлант оны Санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулсан эсэх, бусад холбогдох заавар журмын дагуу бүртгэж тайлагнасан.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 210 дугаар тогтоолоор "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмыг шинэчлэн батлагдсан байна.

Энэхүү "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын зорилго нь банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийг урьдчилан тооцох, үнэлэх, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хорооноос тогтоож, түүний биелэлтэд хяналт тавихад оршино.

Банк бус санхүүгийн байгууллага нь дараах мэдээг:

1. Зээл олголт, эргэн төлөлт, зээлийн зориулалт, хүүгийн судалгааны мэдээ;

2. Факторингийн үйлчилгээ

Тайлан мэдээг санхүүгийн тайлангийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгож, өссөн дүнгээр тайлагнасан байна.

2.2 Санхүүгийн бүртгэлийн программын тухай

Компанийн үйл ажиллагаанд ашиглаж буй Интерактив Би Ай ХХК компанийн Spinel 6.0 системийг ашиглаж санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, үйл ажиллагаанд ашиглаж байна.

PBS-AUDIT

2.3 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж нэгж байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн ерөнхий журам

Санхүүгийн хөрөнгөд мөнгөн хөрөнгө, авлага, зээл, бусад байгууллагын өмчийн хэрэгсэл, санхүүгийн хөрөнгийг авах гэрээний эрх үүсмэл санхүүгийн хэрэглүүр, тэдгээртэй ижил төстэй гэрээ, хэлцэл багтана.

Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь аж ахуйн нэгжид орох нэлээд их магадлалтай, хөрөнгийн өртгийг найдвартайгаар хэмжиж чадах үед хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. ТЗЭ нь санхүүгийн хэрэгслийн гэрээний нэг тал болсон үед санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Гадаад валютаар илэрхийлсэн хөрөнгө өр төлбөрийг Монгол банкнаас зарласан албан ханшаар үнэлж, ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой, богино хугацаат өндөр хөрвөх чадвартай хөрөнгө юм. Мөнгөн хөрөнгөд касс дахь бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө багтана.

Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь 90 хоног буюу 3 сарын дотор мөнгөнд хөрвөх чадвартай, ямар нэгэн нөхцөлөөр хязгаарлагдаагүй байна. Энэ шалгуурыг хангаагүй мөнгөтэй адилтгах хөрөнгийг банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, эсхүл хөрөнгө оруулалтаар бүртгэнэ.

Мөнгөн гүйлгээний тайлан: Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд хоёр жилээр зэрэгцүүлэн харуулна. Мөнгөн гүйлгээний тайланг шууд аргаар бэлтгэсэн.

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь тухайн ТЗЭ-ийн зээлийг буцаан төлөх, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны хүчин чадлыг хэвээр хадгалах, ногдол ашиг төлөх, санхүүжилтийн гадаад эх үүсвэрээс мөнгө авахгүйгээр шинэ хөрөнгө оруулалтыг хийх хангалттай хэмжээний мөнгөн гүйлгээг үйл ажиллагаагаар үүсгэн бий болгох эсэхийг илэрхийлдэг гол үзүүлэлт юм.

Зээл: Зээл гэж банк, эрх бүхий хуулийн этгээдээс гэрээний үндсэн дээр тодорхой зориулалт, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлөөр бусад этгээдэд хүүтэй буюу хүүгүй олгосон мөнгөн хөрөнгийг ойлгоно.

Зээлийг зээлийн гэрээний нэг тал болсон үед санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

Зээлийн хугацаа дуусан, зээлдэгч гэрээнд заасан төлбөрөө барагдуулж, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн, эсхүл гэрээгээр үүссэн эрхээ бусдад бүрэн шилжүүлсэн тохиолдолд зээлийг данснаас хасаж бүртгэнэ.

Зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь хэмжих ба хэрэв зээл олгохтой шууд холбоотой ажил гүйлгээний зардал гарсан бол уг зардлыг бодит үнэ цэнэ дүн дээр нэмэх эсвэл хасах байдлаар хэмжинэ.

Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна.

Зээлийн эрсдэлийн сан (үнэ цэнийн бууралт): ТЗЭ нь Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу сар бүр зээлийн эрсдэлийн санг байгуулна. Түүнчлэн тайлант жилийн эцэст зээлийн үнэ цэнийн бууралтыг СТОУС-9-д нийцүүлэн тооцож болно.

PBS-AUDIT

СТОУС 9-д заасан үнэ цэнийн бууралтын загвар нь хүлээгдэж буй алдагдлын загвар бөгөөд алдагдал үүсэх үйл явдал тохиолдохоос өмнө үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрдөг. Иймд ТЗЭ нь зээлийн үнэ цэнийн бууралтыг хүлээгдэж буй зээлийн алдагдлын дүнгээр үнэлж, бүртгэнэ.

ББСБ нь Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 998 дугаар тогтоолоор батлсан БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН АКТИВЫГ АНГИЛАХ, АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛЖ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ-ыг мөрдөж ажиллаж байна.
Бусад санхүүгийн хөрөнгө: Бусад санхүүгийн хөрөнгө гэж бусад аж ахуйн нэгжээс мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгийг авах гэрээний эрхийг хэлнэ. Хэрэв мөнгө болон санхүүгийн бусад хөрөнгийг авах гэрээний эрх үүсээгүй тохиолдолд уг хөрөнгийг бусад санхүүгийн бус хөрөнгө гэж үзнэ.

Зээлээс бусад тооцооны авлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны авлага, салбар хоорондын тооцоо, өмчлөх бусад хөрөнгө (зээлдэгчээс зээлийн төлбөрт авсан үнэт цаас гэх мэт санхүүгийн хөрөнгө), бусад санхүүгийн хөрөнгийг хамруулна.
Авлагыг эрсдэлийн санг хассан цэвэр дүнтэй тэнцэх хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Гадаад валютаар төлөгдөх авлагыг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх зөрүүг гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзаар хүлээн зөвшөөрнө.

Иргэн, хуулийн этгээд тус бүрээр нэрийн данс нээж хөтөлнө. Авлагын дансны үлдэгдэл нь түр хугацааны шинж чанартай бөгөөд эцсийн тооцоо хийгдэхэд хаагдана.

Санхүүгийн бус хөрөнгө: Санхүүгийн бус хөрөнгө гэж үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт хөрөнгийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй хөрөнгийг хэлнэ.

Санхүүгийн бус хөрөнгөд урьдчилж төлсөн зардал, тооцоо, бараа материал, үнэ бүхий зүйлс, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, тайлант үеийн татварын авлага, хойшлогдсон татварын хөрөнгө, өмчлөх бусад хөрөнгө (хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө), үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө зэрэг хамаарна.

Татвар, НДШ-ийн авлагыг татвар, нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан дүнгээр бүртгэнэ. Тайлагналын өдрөөр татварын төрлөөр авлага, өглөгийг хооронд нь хааж, цэвэр дүнгээр тайлагнана.
Өмчлөх бусад хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт: Зээлдэгч гэрээний нөхцөлийг зөрчиж, барьцаа хөрөнгийг өмчлөх эрхийг ТЗЭ-д шилжүүлсэн буюу зээл, авлагыг барагдуулах зорилгоор ТЗЭ нь зээлдэгчтэй байгуулсан гэрээнд барьцаа болгон заасан хөрөнгийн эзэмших, өмчлөх, захиран зарцуулах эрхийг шилжүүлэн авсан бол **өмчлөх бусад хөрөнгөөр** бүртгэнэ.

Өмчлөх бусад хөрөнгийг холбогдох зээл, хуримтлуулсан хүүгийн авлагын нийт дүн ба (барьцаат хөрөнгийг борлуулаад орох орлогыг зээлийн дүнгээр хязгаарласан нөхцөлд) уг хөрөнгийн тухайн үеийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар нь анх үнэлж, бүртгэнэ.

Зээл, түүнд хамаарах авлагын (хүү ба шимтгэл) дүн нь өмчлөх бусад хөрөнгийн зах зээлийн үнээс их байгаа тохиолдолд өмчлөх бусад хөрөнгийг бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгээр бүртгэж, зээл, түүнд хамаарах авлагын дүнг мөн энэ хэмжээ хүртэл бууруулна. Эдгээрийн зөрүүг өмчлөх бусад хөрөнгийн зардалд бүртгэж, орлогын тайланд толилуулна.

Өмчлөх бусад хөрөнгө байдлаар олж эзэмшсэн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулахаар шийдвэрлэсэн бол уг хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө дансанд шилжүүлж, ангиллыг өөрчилнө. Хэрэв борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөд бүртгэсэн хөрөнгө нь холбогдох тодорхойлолтын шаардлагыг хангахгүй тохиолдолд уг хөрөнгийг өмчлөх бусад хөрөнгөөнд буцаан бүртгэнэ.

PBS-AUDIT

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгө гэж бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслэх эсхүл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа, нэг жилээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй, биет хөрөнгө юм.

Үндсэн хөрөнгийг нийтлэг шинж чанар, зориулалтаар нь барилга байгууламж, компьютер дагалдах хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө гэж ангилна.
Үндсэн хөрөнгийн элэгдлийг доорх ашиглалтын хугацааг баримтлан тооцдог байна.

Хөрөнгийн төрөл:	Элэгдүүлэх хугацаа
Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	10 жил
Компьютер, түүний эд анги	2 жил
Тавилга, эд хогшил	10 жил

Үндсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжинэ. Үндсэн хөрөнгийн өртөг нь хөнгөлөлт ба үнийн бууралтыг хассан үнэ, импортын татвар ба бүцаан үл олгогдох худалдан авалтын татвар, хөрөнгийг ашиглах боломжтой байршил болон нөхцөл байдалд авчрахтай шууд хамааралтай зардал, үндсэн хөрөнгийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах тооцоолсон зардал зэргээс бүрдэнэ.
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ: Үндсэн хөрөнгийн тодорхой бүлэгт багтсан хөрөнгийг дахин үнэлж байгаа тохиолдолд тухайн бүлэгт багтсан үндсэн хөрөнгийг дахин үнэлнэ. Үндсэн хөрөнгийн бүлэг гэж хөрөнгийг ижил төстэй шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь бүлэглэхийг хэлнэ.
Дахин үнэлгээний үед хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтыг тусгасан бодит үнэ цэнийг илтгэх дүнгээр үнэлнэ.
Биет бус хөрөнгө: Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болох мөнгөн бус зүйлсийн хөрөнгө юм. Нэгээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагаа, удирдлагын зориулалтаар ашиглах, биет шинж чанаргүй программ хангамж, гүедвэл болон бусад биет бус хөрөнгүүд хамаарна. Биет бус хөрөнгийг түүнд хуримтлагдсан хорогдуулалтыг хассан цэвэр дүнгээр илэрхийлдэг. Биет бус хөрөнгийн хорогдуулалтыг шулуун шугамын аргаар тооцсон.
Санхүүгийн өр төлбөр: Санхүүгийн өр төлбөр гэж эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн гадагшлах урсгалаар төлөгдөхөөр хүлээгдэж буй өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд үүссэн ТЗЭ-ийн одоогийн үүрэг хариуцлагыг хэлнэ.

ТЗЭ-ийн санхүүгийн өр төлбөрт итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, бусад эх үүсвэр, үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн өр төлбөр, бусад санхүүгийн өр төлбөр, хоёрдогч өглөг, өр төлбөрөөр толилуулах давуу эрхийн хувьцаа хамрагдана.
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр: Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр гэж байгууллага, иргэдээс үр шим амласан болон бусад нөхцөлтэй гэрээгээр байршуулсан эх үүсвэр, хуримтлуулан тооцсон үр шим хамаарах ба итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэрийг хугацаагаар ангилж харуулна.

Итгэлцлийн үйл ажиллагааны гэрээ, хэлцлийн дагуу харилцагч эх үүсвэрийг байршуулж, санхүүгийн хөрөнгийг бүцааж өгөх үүрэг хүлээсэн үед итгэлцлийн үйл ажиллагаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлнэ.
Бусад санхүүгийн өр төлбөр: Бусад санхүүгийн өр төлбөр гэж үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт өр төлбөрийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж буй өр төлбөр буюу ихэнхдээ бусад этгээдэд мөнгө ба бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхээр хүлээсэн гэрээний үүргийг ойлгоно.
Бусад санхүүгийн өр төлбөрт хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг, бусдад өгөх өглөг, салбар хоорондын тооцоо, мөнгөн гуйвуулгын өглөг, цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох өглөг, ногдол ашгийн өглөг, мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион, хөрвөх өр төлбөр хамрагдана.

Санхүүгийн бус өр төлбөр: Санхүүгийн бус өр төлбөрт цалингийн өглөг, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, тайлант үеийн орлогын албан татварын өглөг, бусад татварын өглөг, хойшлогдсон татварын өглөг, хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсэд байгуулсан нөөц, зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүргийн нөөц, хойшлогдсон орлого, урьдчилж орсон

PBS-AUDIT

орлого, борлуулах зорилгоор эзэмшиж буй өр төлбөр, тэтгэвэр, тэтгэмжийн сан (өр төлбөр), түрээсийн хойшлогдсон орлого хамрагдана.

Ажилтны тэтгэмж: Ажилтны тэтгэмж нь ажил эрхлэлт болон ажлаас халагдсантай холбогдуулан ТЗЭ-ээс олгож буй бүх төрлийн төлбөр, урамшуулал юм. Үүнд цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, шагнал урамшуулал, бусад олговор хамрагдана.

Тэтгэвэр, тэтгэмжийн сангийн өр төлбөр гэж улсын тэтгэврийн сангаас (хуулийн дагуу цалингаас заавал суутгах шимтгэл) гадна тэтгэвэр, тэтгэмж олгох зорилгоор хувийн тэтгэврийн сангаар дамжуулан ажилтнуудаа тэтгэвэр, түүнтэй адил төстэй тэтгэмж олгохоор холбогдох хууль, тогтоомж, журам эсхүл гэрээний дагуу хүлээсэн үүргийг ойлгоно.

Ажилтны богино хугацаат тэтгэмж нь ажилтны байгууллагадаа ажилласан тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор бүрэн барагдуулахаар хүлээгдэж буй тэтгэмж юм. Ажилтны богино хугацаат тэтгэмжид цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ээлжийн амралтын цалин, өвчтэй хугацааны тэтгэмж, цалинтай чөлөө (хуримтлагдах ба үл хуримтлагдах), шагнал, урамшуулал багтана.

Нөөц ба болзошгүй өр төлбөр: Болзошгүй өр төлбөр нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн, төлөх дүн мэдэгдэхгүй байгаа эсхүл төлөх магадлал багатай үүрэг юм.

ТЗЭ нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулиар хүлээсэн болон гэрээний бус одоогийн үүрэгтэй, дүнг нь найдвартай тооцох боломжтой бөгөөд уг үүргийг барагдуулахад хөрөнгө зарцуулах магадлалтай үед нөөцийг хүлээн зөвшөөрнө.

Өөрийн хөрөнгө: Хөрөнгөөс нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг өмч (өөрийн хөрөнгө) гэнэ. Өмч нь хувь нийлүүлсэн хөрөнгө, нэмж төлөгдсөн капитал, халаасны хувьцаа, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, хуримтлагдсан ашиг, алдагдал, бусад өөрийн хөрөнгөөс бүрдэнэ.

Хувь нийлүүлсэн хөрөнгө: Хувьцаа эзэмшигчид ТЗЭ-ийн дүрэмд заасны дагуу хөрөнгө оруулна. ТЗЭг нээлттэй хэлбэрээр зохион байгуулсан тохиолдолд үнэт цаас гаргаж нийтэд санал болгох, худалдах ажиллагаа нь Монгол Улсын "Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль, холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдэх ба нягтлан бодох бүртгэлийг СТОУС, Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомж болон энэхүү зааврын дагуу гүйцэтгэнэ. Хувьцаа нь ТЗЭ-ийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байна.

Хувьцаа нь энгийн хувьцаа ба давуу эрхийн хувьцаа гэсэн хоёр төрөлтэй байна.

Давуу эрхийн хувьцаа нь бусад төрлийн хувьцаа, ялангуяа энгийн хувьцаатай холбоотой зарим нэг давуу эрхийг агуулсан хувьцаа юм. Давуу эрхийн хувьцааны нөхцөлөөс шалтгаалан өмч, эсхүл өр төлбөрөөр бүртгэж, тайлагнана.

Өмчийн бусад хэсэг: Өмчийн бусад хэсэг (бусад өөрийн хөрөнгө) нь нөөцийн сан, гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц, эрсдэлийн сангийн нөөц, нийгмийн хөгжлийн сан, хувьцаанд хөрвөх үнэт цаас, хувьцаанд хөрвөх эх үүсвэр, бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны дахин үнэлгээний сан, хейжийн хэрэгслийн дахин үнэлгээний сан зэргээс бүрдэнэ.

Орлого: Орлогод орлого болон олз багтана. Орлого гэж өмч эзэмшигчдээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий хөрөнгийн орлогын гүйлгээ буюу сайжруулалт, эсхүл өр төлбөрийн бууралт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөжийн өсөлт юм.

Хүүгийн орлого нь тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглуулсны төлөө авч буй төлбөр юм.

Хөрөнгийн өсөлт эсхүл өр төлбөрийн бууралттай холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийн нэмэгдэлт үүссэн бөгөөд түүнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд орлогын тайланд орлогыг хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн авсан мөнгө эсхүл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшинг ашиглан тооцож, үнэлнэ. Гэрээний дагуу нэмэлт төлбөр, хойшлогдсон орлого, зардал гараагүй нөхцөлд хүүгийн орлогыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ. Хямдруулалт, урамшуулал, хойшлуулсан орлого, зардлыг холбогдох санхүүгийн хэрэгслийн хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хуваарилж, бүртгэнэ.

Зардал: Зардалд зардал болон гарз багтана. Зардал гэж өмч эзэмшигчдэд олгосон хуваарилалттай холбоотойгоос бусад байдлаар өмчийг багасгах үр дүн бүхий хөрөнгийн зарлагын

PBS-AUDIT

гүйлгээ буюу хорогдон багасалт, эсхүл өр төлбөрийн үүсэлт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөжийн бууралт юм.
Хүүгийн зардал нь ТЗЭ-ийн үйл ажиллагааны эх үүсвэрт ашиглах зорилгоор бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлбөр буюу өртөг байна.

Хөрөнгийн бууралт эсхүл өр төлбөрийн өсөлттэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийн багасалт үүссэн бөгөөд түүнийг найдвартайгаар хэмжиж чадах тохиолдолд орлогын тайланд зардлыг хүлээн зөвшөөрнө.

Зардлыг төлсөн мөнгө эсхүл үүссэн өглөгийн бодит үнэ цэнээр үнэлнэ.

Хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшнээр тооцож үнэлнэ. Татан төвлөрүүлсэн эх үүсвэртэй холбоотой нэмэлт урамшуулал, хямдруулалт, хойшлогдсон орлого болон зардал гараагүй нөхцөлд хүүгийн зардлыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ.

Зардалд хүүгийн зардал, эрсдэлийн сангийн зардал, арилжааны зардал, үнэлгээний өөрчлөлтийн гарз, үйл ажиллагааны бусад зардал хамрагдана.

Орлогын албан татвар: Нягтлан бодох бүртгэлийн ашиг, алдагдал (татварын өмнөх ашиг, алдагдал) гэж санхүүгийн бүртгэлээр тооцоолж гаргасан, тайлант үеийн татварын зардлыг хасахын өмнөх ашиг, алдагдлыг хэлнэ.

Татвар ногдуулах орлого (татварын алдагдал) гэж Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын татварын хуулийн дагуу тооцож, тухайн дүнгээс тайлант үед төлөх орлогын албан татварыг тооцох орлогыг хэлнэ.

Тэнцлийн гадуурх данс: Тэнцлийн гадуурх данс нь зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг, болзошгүй үүрэг, барьцаа хөрөнгө, тэнцлээс хассан хөрөнгө, үүсмэл санхүүгийн хэрэглүүр, барьцаанд тавьсан хөрөнгө зэрэг үйл ажиллагааг бүртгэх данс юм.

Барьцаа хөрөнгө: Барьцаа хөрөнгө гэж зээл, зээлтэй адилтгах хөрөнгөтэй холбогдуулан эргүүлэн авах нөхцөлтэйгөөр харилцагчаас барьцаа болгон өгсөн хөрөнгийг ойлгоно. Барьцаа хөрөнгөнд санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө багтана. Барьцаа хөрөнгийг зээл олгосон өдрийн зах зээлийн үнээр бүртгэнэ.

Барьцаа болгон хүлээн авсан хөрөнгийг тэнцлийн гадуур бүртгэнэ. Зээлдэгч зээл, авлагынхаа төлбөл зохих нийт дүнг хугацаанд нь төлсөн тохиолдолд барьцаанд авсан хөрөнгийг уг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна. Зээлдэгч төлбөрөө хугацаанд нь барагдуулж чадаагүй бөгөөд шүүхээс зээлийн үлдэгдэл төлбөрийг хаахын тулд барьцаанд авсан хөрөнгийг эзэмших эрхийг ТЗЭ өөртөө шилжүүлэн авахыг зөвшөөрсөн тохиолдолд тухайн хөрөнгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна. Уг хөрөнгийг өмчлөх бусад хөрөнгийн дансанд ("Бусад санхүүгийн хөрөнгө" эсхүл "Бусад санхүүгийн бус хөрөнгө") бүртгэх бөгөөд санхүүгийн байдлын тайланд толилуулна.
Тэнцлээс хассан хөрөнгө: Холбогдох хууль, журмын дагуу эргэн төлөгдөхгүй гэж үзсэн ТЗЭ-ийн албан ёсны шийдвэрт үндэслэн санхүүгийн тэнцлээс хассан хөрөнгө юм. Хассан хөрөнгийг тэнцлээс хассан дүнгээр нь бүртгэнэ.

2. Зээлийн үлдэгдэл төлбөрийг төлүүлэх арга хэмжээ үргэлжлүүлэн авах талаар тодорхой тусгана (Шүүхэд нэхэмжлэл гаргах, өр барагдуулах байгууллагад хандах). Зээлийн төлбөрийг барагдуулахад шаардагдах зардал ямар байхыг тогтоож, цаашид өр авлагыг барагдуулах чиглэлээр авах арга хэмжээг эрчимжүүлэн, гаргасан шийдвэр, авч хэрэгжүүлж буй арга хэмжээг баримтжуулна. Зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийн аль нэг нь зээлийн гэрээнд заасан хугацаанаас хойш 90 хоногийн дотор төлөгдөөгүй бол 91 дэх хоногоос эхлэн хүүг хуримтлуулан тооцохыг зогсоож өмнө нь хуримтлуулсан хүүг буцаана. Буцаасан хүүгийн дүнгээр хуримтлуулж тооцохыг зогсоосон хүү дансанд бүртгэх бөгөөд зээлийн үндсэн төлбөр болон хүүг төлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн авна. Хуримтлуулж тооцохыг зогсоосон хүүг зээлдэгч нэг бүрийн нэрийн дансаар задлан бүртгэх бөгөөд зээл болон хүүг нэгэн зэрэг төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Хэрэв зээлийн хүү төлөгдсөн бол төлөгдсөн дүнгээр тэнцлийн гадуурх данснаас зарлагадаж, санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

PBS-AUDIT

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЛБАН ЁСНЫ НЭР:
"МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС " ББСБ

Санхүүгийн тайлангийн
өдөр 2025.12.31

ҮЛДЭГДЭЛИЙН ТЭНЦЭЛ

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ГҮЙЦЭТГЭЛ /төгрөг/ АУДИТЛАГДСАН 2024.12.31 (төгрөг)		АУДИТЛАГДСАН 2025.12.31 (төгрөг)
А. ХӨРӨНГӨ	-		-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	437,460,585.8		707,673,566.5
Зээл	4,777,275,253.5		8,256,959,240.5
Факторингийн тооцооны авлага	4,636,593,765.0		2,276,357,032.7
Бусад санхүүгийн хөрөнгө	417,337,444.7		477,375,232.7
Санхүүгийн хөрөнгийн дүн	**10,268,667,049.0**	-	**11,718,365,072.3**
Татвар, НДШ-ийн авлага	55,691,396.0		-
Үндсэн хөрөнгө	2,789,672.3		11,712,449.2
Биет бус хөрөнгө	428,600.1		1,818,993.8
Бусад санхүүгийн бус хөрөнгө	-		3,997,115.0
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	**58,909,668.3**	-	**17,528,558.0**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**10,327,576,717.3**	-	**11,735,893,630.4**
Бусад эх үүсвэр	2,355,163,290.4		2,787,000,000.0
Бусад санхүүгийн өр төлбөр	10,651,185.6		668,731.0
Санхүүгийн өр төлбөрийн дүн	**2,365,814,476.0**	-	**2,787,668,731.0**
Татвар, НДШ-ийн өр төлбөр	90,609,723.2		72,634,791.1
Санхүүгийн бус өр толбөрийн дүн	**90,609,723.2**	-	**72,634,791.1**
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	**2,456,424,199.2**	-	**2,860,303,522.1**
Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000,000,000.0		5,000,000,000.0
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	2,871,152,518.2		3,875,590,108.3
НИЙТ ӨМЧИЙН ДҮН	**7,871,152,518.2**	-	**8,875,590,108.3**
1. Хүүгийн орлого	1,282,411,195.2	-	2,442,795,820.4
2. Хүүгийн зардал	231,031,232.9	-	899,174,479.5
3. Хүүгийн цэвэр орлого	**1,051,379,962.2**	-	**1,543,621,341.0**
5. Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	**1,051,379,962.2**	-	**1,543,621,341.0**
6. Бусад орлого	48,557,886.7	-	40,096,389.2
7. Бусад зардал	481,144,560.1	-	464,674,402.3
Татварын өмнөх цэвэр орлого, алдагдал	**618,793,288.8**	-	**1,119,043,327.8**
Орлогын татварын зардал	6,187,932.9	-	114,605,737.7
Татварын дараах цэвэр орлого, алдагдал	**612,605,355.9**	-	**1,004,437,590.1**
Хувьцаат капиталын дүн	5,000,000,000.0	-	5,000,000,000.0
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	2,871,152,518.2	-	3,875,590,108.3
НИЙТ ДҮН	**7,871,152,518.2**	-	**8,875,590,108.3**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**10,742,984,763.4**	-	**17,875,547,075.9**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**14,655,313,000.1**	-	**17,349,145,551.4**
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**204,807,958.8**	-	**270,212,980.7**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	**232,652,627.0**	-	**437,460,585.8**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	**437,460,585.8**	-	707,673,566.5

Нэмэлт тодотголууд нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЛБАН ЁСНЫ НЭР:
"МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ ПАРТНЕРС " ББСБ

Санхүүгийн тайлангийн
өдөр 2025.12.31

ҮЛДЭГДЭЛИЙН ТЭНЦЭЛ

ГҮЙЦЭТГЭЛ /төгрөг/

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	АУДИТЛАГДСАН 2024.12.31 (төгрөг)		АУДИТЛАГДСАН 2025.12.31 (төгрөг)
А. ХӨРӨНГӨ	-		-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	437,460,585.8		707,673,566.5
Зээл	4,777,275,253.5		8,256,959,240.5
Факторингийн тооцооны авлага	4,636,593,765.0		2,276,357,032.7
Бусад санхүүгийн хөрөнгө	417,337,444.7		477,375,232.7
Санхүүгийн хөрөнгийн дүн	**10,268,667,049.0**	-	**11,718,365,072.3**
Татвар, НДШ-ийн авлага	55,691,396.0		-
Үндсэн хөрөнгө	2,789,672.3		11,712,449.2
Биет бус хөрөнгө	428,600.1		1,818,993.8
Бусад санхүүгийн бус хөрөнгө	-		3,997,115.0
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	**58,909,668.3**	-	**17,528,558.0**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**10,327,576,717.3**	-	**11,735,893,630.4**
Бусад эх үүсвэр	2,355,163,290.4		2,787,000,000.0
Бусад санхүүгийн өр төлбөр	10,651,185.6		668,731.0
Санхүүгийн өр төлбөрийн дүн	**2,365,814,476.0**	-	**2,787,668,731.0**
Татвар, НДШ-ийн өр төлбөр	90,609,723.2		72,634,791.1
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	**90,609,723.2**	-	**72,634,791.1**
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	**2,456,424,199.2**	-	**2,860,303,522.1**
Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000,000,000.0		5,000,000,000.0
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	2,871,152,518.2		3,875,590,108.3
НИЙТ ӨМЧИЙН ДҮН	**7,871,152,518.2**	-	**8,875,590,108.3**
1. Хүүгийн орлого	1,282,411,195.2	-	2,442,795,820.4
2. Хүүгийн зардал	231,031,232.9	-	899,174,479.5
3. Хүүгийн цэвэр орлого	**1,051,379,962.2**	-	**1,543,621,341.0**
5. Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	**1,051,379,962.2**	-	**1,543,621,341.0**
6. Бусад орлого	48,557,886.7	-	40,096,389.2
7. Бусад зардал	481,144,560.1	-	464,674,402.3
Татварын өмнөх цэвэр орлого, алдагдал	**618,793,288.8**	-	**1,119,043,327.8**
Орлогын татварын зардал	6,187,932.9	-	114,605,737.7
Татварын дараах цэвэр орлого, алдагдал	**612,605,355.9**	-	**1,004,437,590.1**
Хувьцаат капиталын дүн	5,000,000,000.0	-	5,000,000,000.0
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	2,871,152,518.2	-	3,875,590,108.3
НИЙТ ДҮН	**7,871,152,518.2**	-	**8,875,590,108.3**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**10,742,984,763.4**	-	**17,875,547,075.9**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**14,655,313,000.1**	-	**17,349,145,551.4**
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**204,807,958.8**	-	**270,212,980.7**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	**232,652,627.0**	-	**437,460,585.8**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	**437,460,585.8**	-	**707,673,566.5**

Нэмэлт тодотголууд нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.